



АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Нийцлийн аудитын газар

Газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор

Б.Алтанзул

Аудитын менежер
Х.Болдбаатар
Ахлах аудитор
Д.Отгонбаяр
Аудитор
Ц.Гэрэл

2017 оны 10 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Вэб
сайтаас үзнэ үү.
www.audit.mn

Аудитын тайлан
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
261729, 260949
дугаарын утас, факсаар
харилцана уу.

Хаяг:

Үндэсний аудитын
газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3
Засгийн газрын
ІҮ байр
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

Агуулга	1
Товчилсон үгийн жагсаалт	2
Хүснэгт, график, зурган мэдээллийн жагсаалт	2
Аудит хийх үндэслэл, аудитын нэр, код	3
Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй	3
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
Аудит хийсэн хугацаа, багийн бүрэлдэхүүн	4
Үндсэн мэдээлэл	4
БҮЛЭГ 1. Нам, нэр дэвшигчид зарим иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив хуульд заасан хэмжээ, шаардлагад нийцээгүй байна	5-7
БҮЛЭГ 2. Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлыг зарцуулахдаа Төрийн аудитын байгууллагаас тогтоосон зардлын дээд хэмжээг баримталсан байна.....	8-1
БҮЛЭГ 3. Нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд гаргаж ирүүлсэн байна.....	12-15
Дүгнэлт	16
Зөвлөмж	17-18
Холбогдох байгууллагын санал	19
Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	20



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АН	Ардчилсан Нам
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
НАГ	Нийцлийн аудитын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	Намуудад иргэдийн өгсөн хандивийн мэдээлэл
Хүснэгт 2	Нэр дэвшигчдэд хуулийн этгээдээс өгсөн хандивын мэдээлэл
Хүснэгт 3	Намуудын зардлын данснаас зарлага гаргасан байдал
Хүснэгт 4	Нэр дэвшигчдийн зардлын зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл
Хүснэгт 5	Сонгуулийн штабын бүрэлдэхүүний тоог хэтрүүлсэн байдал
Хүснэгт 6	Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн судалгаа, мэдээлэл
График 1	Нэр дэвшигчдэд иргэдээс өгсөн хандивын мэдээлэл
График 2	Намуудын зарцуулсан зардлын хэмжээний мэдээлэл
График 3	Нэр дэвшигчдийн зарцуулсан зардлын байдал



1. Аудит хийх үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт, Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3, 60.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

2. Аудитын нэр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх

3. Аудитын код:

ҮАГ-НАГ/2017/06-НА

4. Аудитын зорилт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн авсан хандив, санхүүжилт болон зардлын тайланг хянан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудит хийхээр төлөвлөсөн. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс хууль тогтоомжид нийцүүлэн хандив өгсөн эсэх;
- Нам, нэр дэвшигчийн авсан хандив, санхүүжилт болон зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын санхүүжилт болон зарцуулалтыг тайлагнасан эсэх.

5. Хамрах хүрээ:

Аудитад Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн сонгуулийн хандивын болон зардлын дэлгэрэнгүй тайлан, хандивлагчийн мэдээлэл, гэрээ, холбогдох төрийн байгууллагуудын тайлан, бүртгэл судалгаа, мэдээлэл, бусад шаардлагатай санхүүгийн баримт материалуудыг хамруулан шалгалаа.

6. Арга зүй:

Тухайн аудитад АДБОУС 100, 400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс хууль тогтоомжид нийцүүлэн хандив өгсөн эсэхийг холбогдох байгууллагуудаас авсан мэдээлэл, нотлох зүйлсэд үндэслэн нягтлан шалгах, нам, нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэн СЕХ-д хүргүүлсэн сонгуулийн зардлын санхүүгийн тайланг холбогдох баримт, материал, мэдээлэл, судалгаатай харьцуулах, Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4.1-д заасны дагуу нам, нэр дэвшигчийн авсан хандив, санхүүжилт болон зарцуулалтын явцад хяналт тавих зорилгоор радио, телевизийн төлбөртэй сурталчилгааны нэвтрүүлэг, сонгуулийн штабын бүрэлдэхүүн, хандивын дансны мэдээлэл зэргийг түүвэрлэн, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горим арга зүйг ашиглаж аудитын дүн, дүгнэлт зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.



7. Аудит хийхэд ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, сонгуулийн санал авах өдрийг тогтоох тухай” 13 дугаар тогтоол;
- Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох тухай” А/31 дүгээр тушаал;
- Холбогдох бусад хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам.

8. Аудит хийсэн хугацаа, багийн бүрэлдэхүүн:

Аудитыг УАГ-ын НАГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Алтанзул хянан удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитор Ц.Гэрэл нар 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд төлөвлөлтийг хийж, 2017 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг хийж гүйцэтгэлээ.

9. Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд Сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх эрхтэй” гэж заасны дагуу МАН-аас Миеэгомбын Энхболд, АН-аас Халтмаагийн Баттулга, МАХН-аас Сайнхүүгийн Ганбаатар нарыг нэр дэвшүүлэн оролцсон байна.

УИХ-ын 2017 оны 13 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн анхан шатны санал авах ажиллагааг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар тогтоосон хэдий ч Сонгуулийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч анхан шатны сонгуулийн нэгдсэн дүнгээр олонхийн санал авч чадаагүйгээс СЕХ-ны 2017 оны 43 дугаар тогтоолоор хоёр дахь санал хураалтыг 2017 оны 07 дугаар сарын 07-ны өдөр явуулахаар товлон зарлаж зохион байгуулжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоох тухай” 2017 оны А/31 дүгээр тушаалаар намын зардлын дээд хэмжээг 6,800.0 сая, нэр дэвшигчийн зардлын дээд хэмжээг 3,900.0 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

**НЭГ. НАМ, НЭР ДЭВШИГЧИД ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ӨГСӨН ХАНДИВ ХУУЛЬД
ЗААСАН ХЭМЖЭЭ, ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА****1.1. Иргэд намд хандив өгөхдөө хуульд заасан хэмжээг баримтлаагүй байна**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон МАН, АН-уудад Сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт “Хандивлагч нь энэ хуульд заасан шаардлага хангасан, Монгол Улсын иргэн байна” гэж заасны дагуу сонгуулийн хугацаанд нийт 5711 иргэн 13,203.7 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна.

Харин МАХН нь сонгуулийн сурталчилгаанд намын сонгуулийн зардлын дансаар орлого, зардлагын гүйлгээ хийгээгүй, зөвхөн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансыг ашигласан байна. Иргэдийн өгсөн хандивын мэдээллийг хүснэгт 1-д харуулбал:

Хүснэгт-1:

Үзүүлэлт	МАН	АН	МАХН	Нийт
Намд хандив өгсөн иргэдийн тоо	3494	2217	0	5711
Намд иргэдээс өгсөн хандивын хэмжээ /сая.төг/	6,611.5	6,592.3	00.0	13,203.8

МАН-ын сонгуулийн хандивын дансанд иргэн Х.Уранчимэг /регистрийн дугаар ПА83050826/-ээс 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдөр 2.5 сая төгрөгийн, 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдөр 2.4 сая төгрөгийн үнийн дүнгээр хоёр удаа хандив өгсөн нь Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэгт заасан “Иргэн хуулийн этгээд нь нэг нам, эвсэл болон нэр дэвшигчид жилд зөвхөн нэг удаа хандив өгч болно” гэсэн заалтыг зөрчсөнийг илрүүлсэн бөгөөд аудитын явцад нам хандивлагчид буцаан шилжүүлж залруулга хийсэн болно.

Мөн АН сонгуулийн дансандаа хандив өгсөн 2217 иргэний хандивыг хүлээж авахдаа Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтад тусгасан мөнгөн хандивын хэмжээ хэтрүүлсэн болон мөн зүйлийн 50.4¹ дэх хэсэгт заасан шаардлагын дагуу банкны гүйлгээний баримтад регистрийн дугаараа тусгаагүй 51.6 сая төгрөгийн хандивыг хандивлагчид тухай бүр буцаан шилжүүлж залруулсан байна.


Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт Төрийн аудитын байгууллага нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэнийг нийтэд зарлахаар заасны дагуу тухайн хандивлагчдын мэдээллийг нэгтгэн байгууллагын цахим сайтад байршуулж, нийтэд мэдээлэв.

1.2. Хандивлагч хуульд заасан шаардлагыг хангаагүй байна

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон МАН-аас нэр дэвшигч М.Энхболд, АН-аас нэр дэвшигч Х.Баттулга, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар нарт сонгуулийн хугацаанд нийт 5555 иргэн 8,883.9 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна. Нэр дэвшигчдэд иргэдээс өгсөн хандивын тоон мэдээлэл, мөнгөн дүнг график 1-д харуулбал:

¹ Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад заавал тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.

График-1:



Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсэгт “хандив өгөгч иргэн, хуулийн этгээд нь регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад заавал тусгах” гэж заасан боловч МАН-аас нэр дэвшигч М.Энхболдын сонгуулийн хандивын дансанд хандивлагчийн нэр, регистрийн дугаар тусгаагүй 4 гүйлгээний 3.6 сая төгрөгийн орлогыг, мөн МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатарын дансанд хандивлагчийн нэр, регистрийн дугаар тусгаагүй 110 гүйлгээний 2.4 сая төгрөгийн орлогыг аудитын явцад илрүүлсэн бөгөөд нам хандивлагчдад буцаан шилжүүлж залруулсан болно.

Харин АН-аас нэр дэвшигч Х.Баттулгын сонгуулийн дансанд хандив өгсөн 1643 иргэнээс өгсөн хандивыг хүлээж авахдаа Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтад заасан мөнгөн хандивын хэмжээг хэтрүүлсэн болон мөн зүйлийн 50.4² дэх хэсэгт заасан шаардлагын дагуу банкны гүйлгээний баримтад регистрийн дугаараа тусгаагүй 15.6 сая төгрөгийн хандивыг хандивлагчид тухай бүр буцаан шилжүүлэн залруулж хуулийн дээрх заалтад нийцүүлсэн байна.

1.3. Хуулийн этгээдээс нам, нэр дэвшигчдэд өгсөн хандив хуульд заасан хэмжээг баримталсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон МАН, АН, МАХН-уудад сонгуулийн хугацаанд хуулийн этгээдээс хандив өгөөгүй бөгөөд тус намуудаас нэр дэвшигч М.Энхболд, Х.Баттулга, С.Ганбаатар нарт Сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3³ дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн хугацаанд нийт 37 хуулийн этгээдээс 498.0 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна. Хандивын нэгтгэсэн мэдээллийг хүснэгт 2-т харуулбал:

Хүснэгт-2:

Үзүүлэлт	Х.Баттулга	М.Энхболд	С.Ганбаатар	Нийт
Нэр дэвшигчид хандив өгсөн хуулийн этгээдийн тоо	18	17	2	37
Нэр дэвшигчид хуулийн этгээдээс өгсөн хандивын хэмжээ /сая.төг/	250.0	218.0	30.0	498.0

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт Төрийн аудитын байгууллага хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлахаар заасны дагуу тухайн хандивлагч хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэн байгууллагын цахим сайтад байршуулж, нийтэд мэдээлэв.

² Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад заавал тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.

³ Энэ хуулиар хориглоогүй, түүнчлэн тухайн хуулийн этгээдийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээд хандивлагч байж болно



1.4. Хандивлагч хуулийн этгээд хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.8 дахь заалтад “шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан, банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд” хандив өгөхийг хориглосон байхад шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр төлбөртэй “Милл Хаус” ХХК нь АН-аас нэр дэвшигч Х.Баттулгад 15.0 сая төгрөгийн хандив өгснийг аудитын явцад илрүүлсэн бөгөөд Сонгуулийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2⁴ дахь хэсэгт заасны дагуу нам хандивлагчид буцаан шилжүүлж залруулсан болно.

Харин МАН-аас нэр дэвшигч М.Энхболдын сонгуулийн дансанд 18 хуулийн этгээдээс өгсөн 250.0 сая төгрөгийн хандив болон МАХН-ын нэр дэвшигч С.Ганбаатарын дансанд 2 хуулийн этгээдээс өгсөн 30.0 сая төгрөгийн хандив нь хуульд заасан хэмжээ, шаардлагад нийцсэн байна.

⁴ Хандив өгөхийг хориглосон этгээд сонгуулийн хандив өгсөн бол хандив хүлээн авах эрх бүхий этгээд буцаан шилжүүлнэ.




ХОЁР. НАМ, НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ЗАРЦУУЛАХДАА ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ТОГТООСОН ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ БАРИМТАЛСАН БАЙНА.

2.1. Нам сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон МАН, АН, МАХН-ууд нь сонгуулийн дансанд хуримтлагдсан хандив, санхүүжилтийг зарцуулахдаа Сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6⁵ дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын байгууллагын тогтоосон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд намаас зарцуулах зардлын дээд хэмжээг баримталж ажилласан байна.

Намуудын зарцуулсан зардлын хэмжээг Төрийн аудитын байгууллагаас тогтоосон зардлын дээд хэмжээтэй харьцуулсныг график 2-оор харуулбал:

График-2:



Сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэгт “...намууд нь сонгуулийн зардлыг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэхээс бусад зориулалтаар тухайн сонгуулийн хугацаанд тухайн нам, хамтарсан намуудын сонгуулийн зардлын данснаас зарлага гаргахыг хориглоно” гэж заасны дагуу сонгуульд оролцсон намууд зардлын данснаас зарлага гаргасан байдлыг хүснэгт 3-д харуулбал:

Хүснэгт-3:

Үзүүлэлт		МАН	АН	МАХН
Эхний үлдэгдэл		00.0	00.0	00.0
Орлого /сая.төг/	Намын өөрийн хөрөнгө	100.0	-	00.0
	Намд иргэдээс өгсөн хандив	6,611.4	6,592.2	00.0
	Нэр дэвшигчийн данснаас	-	33.9	-
Нийт орлого /сая.төг/		6,711.4	6,626.1	00.0
Зарлага /сая.төг/	Нэр дэвшигчийн дансанд шилжүүлсэн	6711.4	-	00.0
	Сонгуулийн зардалд шууд зарцуулсан	-	6,626.1	-

Хүснэгтээс үзвэл Сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2⁶, 44.4⁷ дэх хэсгүүдэд намын сонгуулийн зардлын данснаас зарлага гаргах талаар эрх зүйн зөрүүтэй

⁵ Намын ... тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зарцуулалтын хэмжээ энэ хуульд нийцсэн байна.

⁶ Ерөнхийлөгчийн сонгуулиар нам дангаар болон хамтарч нэр дэвшүүлсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан хүргүүлэх өдрийг дуустал, хугацаанд намын сонгуулийн зардлын данснаас зарлага гаргаж болно.

⁷ Ерөнхийлөгчийн сонгуулиар нэр дэвшүүлсэн нам, хамтарсан намууд нь сонгуулийн зардлыг Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэхээс бусад зориулалтаар тухайн сонгуулийн хугацаанд тухайн нам, хамтарсан намуудын сонгуулийн зардлын данснаас зарлага гаргахыг хориглоно.



зохицуулалттайгаас шалтгаалан МАН нь сонгуулийн зардлын дансанд хуримтлагдсан нийт орлого 6,711.4 сая төгрөгийг нэр дэвшигчийнхээ дансанд шилжүүлж зарцуулсан бол АН нь сонгуулийн зардлын дансанд хуримтлагдсан нийт орлого 6,626.1 сая төгрөгийг сонгуулийн зардалд шууд зарцуулж тайлагнасан байна.

2.2. Намууд хувийн аудитын байгууллагатай байгуулсан гэрээг дүгнээгүй байна

Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэгт “...Нам, эвсэл нь зардлын тайландаа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна” гэж заасныг баримтлан МАН “Далайван Аудит” ХХК-аар, АН “Энүр Аудит” ХХК-иар тус тус аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах 2 талт гэрээ байгуулсан байна.


Гэрээний дагуу намын сонгуулийн зардлын зарцуулалтын тайланд дээрх хувийн аудитын компаниуд нь санхүүгийн тайлангийн аудит хийж тус намуудад зөрчилгүй санал дүгнэлт гаргаж СЕХ-д хүргүүлсэн хэдий ч гэрээнд оролцогч талууд гэрээг дүгнэж, гүйцэтгэлийг үнэлэх заалт тусгаагүйгээс гэрээний хэрэгжилтийн байдлыг дүгнээгүй байна.

Харин МАХН нь сонгуулийн сурталчилгаанд намын сонгуулийн зардлын дансаар орлого, зардлагын гүйлгээ хийгээгүй тул аудит хийлгэх гэрээ байгуулаагүй байна.

2.3. Нэр дэвшигчид сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон МАН-аас нэр дэвшигч М.Энхболд, АН-аас нэр дэвшигч Х.Баттулга, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар нар нь сонгуулийн зардлын дансанд хуримтлагдсан хандив, санхүүжилтийг зарцуулахдаа Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.10⁸ дахь хэсэгт заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээ тогтоосныг баримталж ажилласан байна. Нэр дэвшигчдийн зарцуулсан зардлын хэмжээг Төрийн аудитын байгууллагаас тогтоосон зардлын дээд хэмжээтэй харьцуулж график 3-т харуулбал:

График-3:



Сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг зарцуулах зориулалтыг заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалтын байдлыг хүснэгт 4-д харуулбал:

Хүснэгт-4:

№	Үзүүлэлт	Х.Баттулга	М.Энхболд	С.Ганбаатар
Зарлага /сая.төг/	1 Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал	925.7	2,035.9	269.4
	2 Нам нэр дэвшигчийг сурталчлах зардал	1,127.5	684.2	1,096.2
	3 Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал	-	792.4	-
	4 Бичиг хэргийн зардал	82.5	11.1	-
	5 Шуудан холбооны зардал	348.3	298.5	-

⁸ Нэр дэвшигчийн ...тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зарцуулалтын хэмжээ энэ хуульд нийцсэн байна.



6	Унааны зардал	455.7	1,111.7	-
7	Албан томилолтын зардал	545.8	146.4	-
8	Хөлс урамшууллын зардал	-	1,631.2	1,600.6
	ЗАРДЛЫН ДҮН	3,485.5	6,711.4	2,966.2
	Үлдэгдэл	20.2	3.97	3.01

Сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.4⁹ дэх заалтад тусгасан ажилд мөнгөн хөрөнгө зарцуулахаар заасан хэдий ч мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.5¹⁰ дахь хэсэгт заасны дагуу Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал гаргуулах журам”-д хөлс урамшууллын зардал болон, хэнд хөлс урамшуулал олгох зохицуулалт тусгаагүй зэрэг нь эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэсэн байна.

Мөн Сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2¹¹ дахь хэсэгт сонгуулийн штабын бүрэлдэхүүнд ажиллуулах менежер, шадар туслагч, ухуулагчийн тоог тогтоож өгсөн хэдий ч нам, нэр дэвшигч нь ажиллах хүний тоог хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох зохицуулалт хуульд тусгаагүйгээс сонгуульд оролцсон АН болон МАН нь сонгуулийн штабын бүрэлдэхүүний тоог хэтрүүлэн ажиллуулж өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшуулал олгосон байна. Хүснэгт 5-д сонгуулийн штабын бүрэлдэхүүний тоог хэтрүүлсэн байдлыг харуулбал:

Хүснэгт-5:

Үзүүлэлт	Хуулиар тогтоосон тоо	МАН	АН
Сонгуулийн штабын бүрэлдэхүүний тоо	14030	22560	22161

Харин МАХН нь Сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсэгт заасан сонгуулийн штабын бүрэлдэхүүнд ажиллах хүний тоог баримталсан байна.

Сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн штаб сонгуулийн сурталчилгааг зохион байгуулахдаа хувь хүмүүстэй гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлсэн бөгөөд тэдгээр хүмүүст олгосон орлого болон сонгуулийн сурталчилгаанд сонгуулийн штабын бүрэлдэхүүнд ажилласан хүмүүст олгосон өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт шилжүүлэх татвар төлөгчийн үүргээ биелүүлээгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6¹² дахь заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26.1.1¹³ дэх заалт, мөн хуулийн 26.3¹⁴ дахь хэсгийг тус тус зөрчсөн байна.

АН болон тус намаас нэр дэвшигч Х.Баттулга, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар нарын сонгуулийн зардлын тайланд Сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасны дагуу “Энэр Аудит” ХХК, Актив Аудит ХХК-ууд нь аудит хийж дүгнэлт

⁹ Сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна. ... 42.2.4.бичиг хэрэг, шуудан, холбоо, унааны болон албан томилолт, хөлс, урамшуулал;

¹⁰ Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч нь сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд зөвхөн үйл ажиллагааны өдөр тутмын зардлыг сонгуулийн зардлаас гаргуулах бөгөөд холбогдох журмыг сонгуулийн төв байгууллага батална

¹¹ Нэр дэвшигч өөрийн итгэмжлэл олгосон нэг менежертэй байх ба шадар туслагч сонгогч тутамд нэгээс илүүгүй, ухуулагч 200 сонгогч тутамд нэгээс илүүгүй байна.

¹² бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх;

¹³ энэ хуулийн ... 12.2, 13.1.2-13.1.4, 15.1-д заасан орлогын дүнд мөн хуулийн 23.1-д заасан хувиар ... тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;

¹⁴ Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.



гаргахдаа дээрх хувь хүний орлогын албан татвар суутгаж төсөвт шилжүүлэх талаар зөрчил дурдаагүй байна.

Харин МАН болон тус намаас нэр дэвшигч М.Энхболдын сонгуулийн зардлын тайланд “Далайван Аудит” ХХК нь аудит хийх явцад Удирдлагын захидал хэлбэрээр намын удирдлага болон нэр дэвшигчид ажил гүйцэтгэгч хувь хүмүүсээс хувь хүний орлогын албан татвар суутгаж төсөвт шилжүүлэх зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй байна.

Мөн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны ажил гүйцэтгэгч хувь хүмүүс болон сонгуулийн штабын бүрэлдэхүүнд бэлэн мөнгөөр олгосон мөнгөн гүйлгээг хүлээн авагч тал хүлээн авсан баримтыг бүрдүүлээгүй, өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшууллын нэгдсэн тайлан гаргуулаагүй зэргээс шалтгаалан татвар суутгах орлогын хэмжээг тогтоох боломжгүй байна.

2.4. Нэр дэвшигчид хувийн аудитын байгууллагатай байгуулсан гэрээг дүгнээгүй байна

Сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт “...*Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь зардлын тайландаа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна*” гэж заасныг баримтлан МАН болон тус намаас нэр дэвшигч М.Энхболд Далайван Аудит ХХК-иар, АН болон тус намаас нэр дэвшигч Х.Баттулга Энүр Аудит ХХК-иар, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар Актив Аудит ХХК-иар тус тус аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах 2 талт гэрээ байгуулсан байна.

Гэрээний дагуу нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалтын тайланд дээрх хувийн аудитын компаниуд нь санхүүгийн тайлангийн аудит хийж нам, нэр дэвшигч тус бүрт зөрчилгүй санал дүгнэлт гаргаж СЕХ-д хүргүүлсэн хэдий ч гэрээнд оролцогч талууд гэрээг дүгнэж, гүйцэтгэлийг үнэлэх заалт тусгаагүйгээс гэрээний хэрэгжилтийн байдлыг дүгнээгүй байна.

**ГУРАВ. НАМ, НЭР ДЭВШИГЧИД СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГАА ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ГАРГАЖ ИРҮҮЛСЭН БАЙНА****3.1. Намууд сонгуулын зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд гаргаж ирүүлсэн байна.**

УИХ-ын 2017 оны 13 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн анхан шатны санал авах ажиллагааг 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар тогтоосон хэдий ч сонгуулийн анхан шатны санал хураалтаар гурван нэр дэвшигчийн хэн нь ч 50%+1 болзлыг хангаж чадаагүйгээс СЕХ-ноос хоёр дахь санал хураалтыг 2017 оны 07 дугаар сарын 07-ны өдөр явуулахаар товлон зарлаж зохион байгуулсны дагуу сонгуульд оролцсон намууд нь Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэгт заасан сонгуулийн зардлын тайлан гаргах үзүүлэлтийн дагуу тайлагнаж, 57 дугаар зүйлийн 57.3¹⁵ дахь хэсэгт заасан хугацаанд багтааж СЕХ-нд тус тус хүргүүлсэн байна. Үүнд:

- МАН 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 359 дүгээр албан бичгээр,
- АН 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 2017/69 дугаар албан бичгээр,
- МАХН 2017 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 136 дугаар албан бичгээр.

Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэгт нам нь зардлын тайланд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулна гэж заасны дагуу МАН “Далайван Аудит” ХХК-иар, АН “Энүр Аудит” ХХК-иар тус тус аудит хийлгэж, санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж зөрчилгүй дүгнэлт гаргасан байна. Харин МАХН нь сонгуулийн хугацаанд намын сонгуулийн зардлын дансаар орлого, зардлагын гүйлгээ хийгээгүй болно.

Сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсэгт “Нам нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг дараах ¹⁶ төрийн байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу сонгуульд оролцсон намуудын төв байгууллага Төрийн аудитын байгууллагад сонгуулийн зардлын дансны мэдээллийг дараах хугацаанд ирүүлж, бүртгүүлсэн байна. Үүнд:

- МАН 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 90 дугаар албан бичгээр,
- АН 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/77 дугаар албан бичгээр,
- МАХН-ын Дорноговь аймаг дахь намын үүр 2017 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 06/13 дугаар албан бичгээр, Багануур дүүрэг дэх намын үүр 2017 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 20 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн.

3.2. Намуудын сонгуулийн зардлын зарцуулалтад төрийн байгууллагууд хяналт тавьж ажиллах эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

Төрийн аудитын байгууллага Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4 дэх хэсэгт заасан сонгуулийн зардлын тайлангийн талаарх чиг үүргийн дагуу сонгуулийн хугацаанд нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалтад холбогдох хяналтыг хэрэгжүүлэн дараах байгууллагуудаас судалгаа, мэдээлэл гаргуулан авч ажиллав. Үүнд:

Хүснэгт-6:

Судалгаа мэдээлэл ирүүлсэн байгууллагын нэр	Судалгаа мэдээллийн агуулга	Судалгаа, мэдээлэл ирүүлсэн албан бичгийн огноо дугаар
Харилцаа холбооны зохицуулах хороо	МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио,	2017.09.15 №04/1497

¹⁵ Нам, эвсэл нь санал хураал явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайлан гаргаж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

¹⁶ 43.5.3. төрийн аудитын дээд байгууллага



	<i>телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн жагсаалт</i>	
Иргэний нисэхийн ерөнхий газар	<i>МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуультай холбогдуулан нам, нэр дэвшигчид захиалгат нислэг үйлдсэн эсэх мэдээлэл, сонгуулийн хугацааны захиалгат нислэгийн хуваарь</i>	2017.07.04 №1343
Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллага	<i>Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн штабт ажиллаж байгаа шадар туслагч, ухуулагчийн тоон судалгаа</i>	21 аймаг, нийслэлийн хэмжээгээр судалгаа гаргуулж нэгтгэсэн.
Сонгуулийн Ерөнхий хороо	<i>Нам, нэр дэвшигчийн менежер, итгэмжлэгдсэн шадар туслагчаар ажилласан хүмүүсийн бүртгэл</i>	2017.09.12 №165
Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газар	<i>Нам, нэр дэвшигчид хандив өгсөн хуулийн этгээдийн шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өртэй эсэх судалгаа</i>	2017.09.14 №5/1514
Монголбанк	<i>Сонгуулийн хугацаанд нам, нэр дэвшигчийн ашигласан болон идэвхитэй байсан дансны жагсаалт</i>	2017.09.26 №Б-6/1246
Монголбанк	<i>Нам, нэр дэвшигчид хандив өгсөн хуулийн этгээдийн банкны хугацаа хэтэрсэн өртэй эсэх судалгаа</i>	2017.09.26 №Б-6/1246

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт “Хороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:...7.4.8.Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам, нэр дэвшигчийн авсан хандивын хэмжээ, зарцуулалтад хяналт тавих” гэж заасан бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасны дагуу СЕХ-ноос бусад төрийн байгууллага нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавихыг хязгаарласан эрх зүйн зөрчилтэй байдал үүсгэсэн байна. Тухайлбал:

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.18 дахь хэсэгт заасан чиг үүргийн дагуу сонгуулийн хугацаанд нам, нэр дэвшигчидийн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийн хэтрүүлэлтэд хяналт тавьж ажилласан бөгөөд хяналтын дагуу сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн цаг, минут хэтрүүлсэн тохиолдолд нам, нэр дэвшигчдээс төлөгдөх төлбөрийг сонгуулийн зардлын зарцуулалтад уялдуулах хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг журамлаагүй байна.

Мөн Сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан сонгуулын зардлын зарцуулалт, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэгт тусгасан намын сонгуулийн зардлын тайлан гаргах үзүүлэлт зэрэг нь ерөнхий байдлаар тусгагдсан, сонгуулийн зардлын тайлан гаргах заавар, журам, маягт боловсруулж батлаагүйг аудитын явцад тогтоолоо.

3.3. Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны явцад зардал гаргахдаа хуульд заасан шаардлагыг хангаагүй байна

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч М.Энхболд, Х.Баттулга, С.Ганбаатар нар нь Сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсэгт заасан сонгуулийн зардлын тайлан гаргах үзүүлэлтийн дагуу тайлагнаж, мөн хуулийн 58 дугаар зүйлийн 58.1¹⁷ дэх хэсэг заасан хугацаанд СЕХ-нд хүргүүлсэн байна. Үүнд:

¹⁷ “Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайлан гаргаж сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй”



- МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 133 дугаар албан бичгээр,
- АН-аас нэр дэвшигч Х.Баттулга 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдөр,
- МАН-аас нэр дэвшигч М.Энхболд 2017 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 356 дугаар албан бичгээр сонгуулийн зардлын тайлан гаргаж СЕХ-д тус тус хүргүүлсэн.

Сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт “...Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь зардлын тайландаа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна” гэж заасныг баримтлан МАН-аас нэр дэвшигч М.Энхболд “Далайван Аудит” ХХК-иар, АН-аас нэр дэвшигч Х.Баттулга “Энүр Аудит” ХХК-иар, МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар “Актив-аудит” ХХК-иар тус тус аудит хийлгэж, зөрчилгүй дүгнэлт гаргасан байна.

Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэгт “...Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь сонгуулийн зардлын данс нээлгэсэн өдрөөс хойш тав хоногийн дотор дансны дугаар, банкны нэрийг дараах¹⁸ төрийн байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу сонгуульд оролцсон нэр дэвшигчид нь Төрийн аудитын байгууллагад сонгуулийн зардлын данс, банкны мэдээллийг дараах хугацаанд тус тус ирүүлж, бүртгүүлсэн. Үүнд:

- МАН-аас нэр дэвшигч М.Энхболд 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 100 дугаар албан бичгээр,
- АН-аас нэр дэвшигч Х.Баттулга 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн өргөдлөөр,
- МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 48 дугаар албан бичгээр.

Сонгуулийн зардлын данс байршуулсан арилжааны банкууд Сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4¹⁹ дэх хэсэгт заасны дагуу дансдын гүйлгээний тайланг холбогдох үзүүлэлтээр гаргаж, хуульд заасан хугацаанд СЕХ-нд хүргүүлсэн байна. Тухайлбал;

- Төрийн банкны Ард бизнес төвөөс МАН-ын болон нэр дэвшигч М.Энхболдын дансны гүйлгээний тайланг 2017 оны 8 дугаар сарын 04-ний өдөр 24/333 дугаар албан бичгээр,
- Хаан банкны Төв тооцооны төвөөс АН-аас нэр дэвшигч Х.Баттулгын дансны гүйлгээний тайланг 2017 оны 8 дугаар сарын 02-ны өдөр,
- ХААН банкны Сүхбаатар тооцооны төвөөс нэр дэвшигч С.Ганбаатарын дансны гүйлгээний тайланг 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдөр 0511/17-59 дүгээр бичгээр СЕХ-д тус тус хүргүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон МАН, АН, МАХН-уудаас нэр дэвшигчдийн сонгуулийн штаб нь нам, нэр дэвшигчийг сонгуулийн хугацаанд сурталчлах, мөрийн хөтөлбөрийг таниулах, сонгуулийн уулзалт цуглаан зохион байгуулах зэргээр сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулахдаа ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан боловч талууд дүгнээгүй, санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг нийтлэг зөрчил аудитын явцад тогтоогдож байгаа нь Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5²⁰ дэх хэсэгт нийцэхгүй байна. Тухайлбал:

¹⁸ 47.4.3. төрийн аудитын дээд байгууллага

¹⁹ Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.

²⁰ Зардлын тайланг дараах үзүүлэлтээр гаргана: 57.5.4. Зарлагын ангилал, гүйцэтгэл, гэрээний хамт



- Сонгуулийн төв болон салбар хорооноос үнэмлэх олгосон сонгуулийн штабын бүрэлдэхүүнд ажилласан хүмүүсийн жагсаалт, холбогдох материалыг хавсаргаагүй,
- Сонгуулийн штабын ажилтнуудад олгосон өдөр тутмын үйл ажиллагааны зардлын зарцуулалтын дараа тайланг гаргуулаагүй;
- Ажил гүйцэтгэгч байгууллага болон хувь хүмүүст бэлэн мөнгөөр олгосон мөнгөн гүйлгээ хүлээн авагч талын орлого хүлээн авсан баримтгүй;
- Байгуулсан гэрээ нь хуулийн этгээдийн нэр дээр хийгдсэн байхад төлбөрийг хувь хүн хүлээн авсан баримт хавсаргасан;
- Сонгуулийн штабын ажилтнууд хөдөө орон нутагт томилолтоор ажилласан хугацааны зам хоногийн хоолны болон зочид буудалд байрласан баримтгүй зэрэг болно.

3.4. Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалтад төрийн байгууллагууд хяналт тавьж ажиллах эрх зүйн зохицуулалт дутмаг байна

Сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан сонгуулын зардлын зарцуулалт, 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсэгт заасан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах үзүүлэлт зэрэг нь ерөнхий байдлаар тусгагдсан, сонгуулийн зардлын тайлан гаргах заавар, журам, маягт боловсруулж батлаагүйг аудитын явцад тогтоолоо.

Мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчийн сонгуулийн штаб эрхлэн явуулна” гэж заасан хэдий ч сонгуулийн зардлын зарцуулалтын талаар хэрхэн оролцох, ямар үүрэг, хариуцлага хүлээхийг тусгаагүй байна.



ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн нотлох зүйлс, дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.
Үүнд:

1. Сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд зарим иргэд, хуулийн этгээдээс Сонгуулийн тухай хуулийн 50, 52 дугаар зүйлд заасан хэмжээ, шаардлагад нийцээгүй хандив өгсөн байна;
2. Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал гаргуулах журам”-д хөлс урамшууллын зардал болон хэнд хөлс урамшуулал олгох зохицуулалт тусгагдаагүй зэрэг нь эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэсэн байна.
3. Сонгуулийн тухай хуульд нам, нэр дэвшигч нь ажиллах хүний тоог хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох зохицуулалт тусгагдаагүйгээс сонгуульд оролцсон АН болон МАН нь сонгуулийн штабын бүрэлдэхүүний тоог хэтрүүлэн ажиллуулж өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшуулал олгосон байна.
4. Сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн штабаас хувь хүмүүстэй гэрээ байгуулж сонгуулийн сурталчилгааны ажил гүйцэтгүүлэхдээ тэдгээр хүмүүст олгосон орлогоос болон сонгуулийн штабын бүрэлдэхүүнд олгосон өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт шилжүүлэх татвар төлөгчийн үүргээ биелүүлээгүй байна.
5. Сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан сонгуулын зардлын зарцуулалт, 57 дугаар зүйлийн 57.5, 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсгүүдэд тусгасан нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах үзүүлэлт зэрэг нь ерөнхий байдлаар тусгагдсан, сонгуулийн зардлын тайлан гаргах заавар, журам, маягт боловсруулж батлан гаргаагүй байна.
6. Сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн штаб нь ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээг дүгнээгүй, санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг нийтлэг зөрчилтэй байна.
7. Нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалтад төрийн байгууллагууд хяналт тавьж ажиллах эрх зүйн зохицуулалт дутмаг байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна Үүнд:

Сонгуулийн ерөнхий хороонд:

1. Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчийн өдөр тутмын үйл ажиллагааны зардал гаргуулах журам”-д сонгуулийн штабын бүрэлдэхүүнд олгох өдөр тутмын үйл ажиллагааны зардалд хөлс урамшууллын зардал хамаарах эсэх, Сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.4 дэх заалтад тусгасан хөлс урамшууллын зардлыг хэнд олгох зохицуулалтыг нарийвчлан журамлах;
2. Сонгуулийн зардлын тайлан гаргах заавар, журам, маягт боловсруулж батлан гаргах;
3. Нам, нэр дэвшигч нь сонгуулийн штабын бүрэлдэхүүнд ажиллах шадар туслагч, ухуулагчийн тоог хэтрүүлэн ажиллуулж өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшуулал олгосон тохиолдолд хариуцлага тооцдог байх эрх зүйн зохицуулалтыг Сонгуулийн тухай хуульд тусгуулах.

Монгол Ардын Намд:

1. Сонгуулийн тухай хуулийн 50, 52 дугаар зүйлд заасан мөнгөн хандивын хэмжээ, хандивлагчийн шаардлагад нийцээгүй сонгуулийн хандивыг хүлээж авахдаа хуулийн дагуу тухай бүр залруулж байх;
2. Сонгуулийн тухай хуульд заасан сонгуулийн штабын бүрэлдэхүүний тоог хэтрүүлэхгүй байх;
3. Хувь хүмүүстэй гэрээ байгуулж сонгуулийн сурталчилгааны ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхдээ тэдгээр хүмүүст олгосон орлогоос болон сонгуулийн штабын бүрэлдэхүүнд олгосон өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж, төсөвт шилжүүлэн тайлагнаж байх;
4. Сонгуулийн хугацаанд идэвхитэй ашиглах намын нэр дээрх бүх дансны дугаар, банкны мэдээллийг холбогдох байгууллагад бүртгүүлж байх;
5. Сонгуулийн сурталчилгааны ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээг дүгнэж, сонгуулийн зардлын холбогдох санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг хуулийн дагуу бүрэн тайлагнаж байх;

Ардчилсан Намд:

1. Сонгуулийн тухай хуулийн 50, 52 дугаар зүйлд заасан мөнгөн хандивийн хэмжээ, хандивлагчийн шаардлагад нийцээгүй сонгуулийн хандивыг хүлээж авахдаа хуулийн дагуу тухай бүр залруулж байх;
2. Сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг заасны дагуу намын сонгуулийн зардлын орлогыг нэр дэвшигчийн дансанд шилжүүлэлгүйгээр сонгуулийн сурталчилгаанд шууд зарцуулахгүй байх;
3. Сонгуулийн тухай хуульд заасан сонгуулийн штабын бүрэлдэхүүний тоог хэтрүүлэхгүй байх;
4. Хувь хүмүүстэй гэрээ байгуулж сонгуулийн сурталчилгааны ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхдээ тэдгээр хүмүүст олгосон орлогоос болон сонгуулийн штабын бүрэлдэхүүнд олгосон өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж, төсөвт шилжүүлэн тайлагнаж байх;
5. Сонгуулийн хугацаанд идэвхитэй ашиглах намын нэр дээрх бүх дансны дугаар, банкны мэдээллийг холбогдох байгууллагад бүртгүүлж байх;



6. Сонгуулийн сурталчилгааны ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээг дүгнэж, сонгуулийн зардлын холбогдох санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг хуулийн дагуу бүрэн тайлагнаж байх;

Монгол Ардын Хувьсгалт Намд:

1. Сонгуулийн тухай хуулийн 50, 52 дугаар зүйлд заасан мөнгөн хандивийн хэмжээ, хандивлагчийн шаардлагад нийцээгүй сонгуулийн хандивыг хүлээж авахдаа хуулийн дагуу тухай бүр залруулж байх;
2. Хувь хүмүүстэй гэрээ байгуулж сонгуулийн сурталчилгааны ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхдээ тэдгээр хүмүүст олгосон орлогоос болон сонгуулийн штабын бүрэлдэхүүнд олгосон өдөр тутмын үйл ажиллагааны зардал, хөлс урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж, төсөвт шилжүүлэн тайлагнаж байх;
3. Сонгуулийн хугацаанд идэвхитэй ашиглах намын нэр дээрх бүх дансны дугаар, банкны мэдээллийг холбогдох байгууллагад бүртгүүлж байх;
4. Сонгуулийн сурталчилгааны ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээг дүгнэж, сонгуулийн зардлын холбогдох санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг хуулийн дагуу бүрэн тайлагнаж байх;



Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас: 26 09 75, Факс: (976-11) 32 69 75,
E-mail: gecm@gec.gov.mn, <http://www.gec.gov.mn>

2017.11.06 № 354

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Д.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны
ээлжит сонгуульд оролцсон улс төрийн нам болон
нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд
хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

Хүндэтгэсэн,



ДАРГА

Ч.СОДНОМЦЭРЭН

000563

Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/208

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сонгуулийн Ерөнхий хороо /Ч.Содномцэрэн/-д зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /Б.Алтанзул/-т даалгасугай.

5. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэж өгөхийг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /Б.Алтанзул/-т, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /С.Оюунбилэг/-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР